

# САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Харьцуулсан судалгаа

Судалгааны код: СТ-17/220

АГУУЛГА

## Судалгааны хураангуй

УДИРТГАЛ

Нэг.Сайн дурын ажил, үйлчилгээний тухай ерөнхий ойлголт ба түүхэн тойм

Судалгааны Нэгдүгээр хэсэгт, сайн дурын ажил, үйлчилгээний үүсэл хөгжил болон сайн дурын үйл ажиллагааны талаарх ерөнхий ойлголт, Хоёрдугаар хэсэгт, судалгааны захиалгад дурдсан Солонгос, Герман түүнчлэн, Люксембург, Филиппин, Македон, Чех зэрэг улсын сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчинг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалсан болно. Мөн сайн дурын үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулж буй Солонгос, Филиппин, Македон болон Чех улсын холбогдох хууль тогтоомжийг тойм байдлаар орчуулсан болно.

Хоёр.Сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй гадаадын зарим орны эрх зүйн орчин

Судалгааны сэдвийн хүрээнд дээр дурдсан орнуудаас бие даасан зохицуулалт бүхий орнуудын хууль тогтоомжийг хуулийн агуулга, бүтцийн хүрээнд (зохицуулж буй харилцаа, нийтлэг асуудлууд, сайн дурын үйл ажиллагааны тодорхойлолт, хуулийн хамрах хүрээ болон сайн дурын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, сайн дурын үйл ажиллагааг урамшуулах, хамгаалах механизм, сайн дурын үйл ажиллагааны харилцаанд оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлага, татвар гэх мэт) судалсан болно.

2.1.Люксембург

## Судалгааны үр дүнгийн тойм

2.2.ХБНГУ

Сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй зохицуулалтын хувилбаруудын хувьд улс орон бүр өөрийн хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалдаа тохируулан харилцан адилгүй зохицуулалттай байна. Турк, Албани зэрэг улсад сайн дурын ажил, үйлчилгээг зохицуулсан зохицуулалт байхгүй байгаа бол бусад улс орнуудын зохицуулалтыг (Европын холбооны хэмжээнд) үндсэн 3 ангилалд хувааж болохоор байна.

2.3.БНСУ

2.4.Филиппин

2.5.Македон

Эхний ангилалд зан заншлын, өөрөө өөрийгөө зохицуулах хэм хэмжээ бүхий, сайн дурын үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан хууль тогтоомжгүй улс орнууд орж байна Тус ангилалд: Сайн дурын үйл ажиллагаа эртнээс хөгжсөн Скандинавын улс орнууд болон Их Британи, Ирланд зэрэг улс орж байна.

2.6.БНЧУ

Ашигласан материал

Хоёрдугаар ангилалд сайн дурын үйл ажиллагаатай холбоотой харилцааг бие даасан хуулиар бус тус асуудлыг хамаарах олон хуулиар зохицуулсан улс орнууд багтаж байна. Тухайлбал, Латвид “сайн дурын ажилтан”, “сайн дурын үйл ажиллагаа” гэх нэр томъёог Иргэний нийгмийн байгууллагуудыг зохицуулж буй хууль тогтоомжид, Польш Улсад Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хууль тогтоомжид, Швейцарт Эрх үүргийн тухай хуулиар тус тус зохицуулсан байна. Зарим улсын хувьд зөвхөн залуучуудын сайн дурын үйл ажиллагаан дахь оролцоог дэмжсэн, зохицуулсан зохицуулалтууд тусгагдсан (Косово, Беларусь), эсхүл сайн дурын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хөдөлмөрийн хууль, татварын хууль тогтоомжид тусган зохицуулж байна.

Гуравдугаар ангилалд сайн дурын үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулж буй улс орнууд орж байгаа бөгөөд Европын орнуудад хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй хувилбар юм. Үүнд:

Улаанбаатар  
2018 он

Бельги, Литва, Македон, Молдов, Словак, Серб, Украин, ОХУ, Гүрж, Хорват, Чех, Унгар, Итали, Люксембург, Португал, Испани зэрэг улс орнууд багтаж байна.

Дэлхийн улс орнуудын хувьд 2001 оныг НҮБ-аас Олон улсын сайн дурын ажилтны жил болгон зарлаж, холбогдох хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхийн ач холбогдлыг онцолсноос хойш сайн дурын үйл ажиллагааг хуулиар тусгайлан зохицуулах нь нэмэгдсэн.

Сайн дурын ажиллагааны төв /зөвлөл, агентлаг/ (National Volunteer services)-ийг байгуулах нь сайн дурын үйл ажиллагааг дэмжих гол хэрэгслүүдийн нэг болж байна. Эдгээр байгууллагуудаар дамжуулан мэдээлэл олгох, төвлөрүүлэх, сургалт явуулах, зуучлах зэрэг үйл ажиллагаа явагдах бөгөөд Австрали, Аргентин, Барбадос, Бразил, Хорват, Кипр, Египет, Сальвадор, Ливан, Люксембург, Мадагаскар, Перу, БНСУ, Украин, АНЭУ, Замби, Тайланд зэрэг орнууд энэ талаар туршлага хуримтлуулжээ. Улс орон бүрийн хувьд тэдгээрийг байгуулсан зорилго, үйл ажиллагааны хүрээ зэргээс хамааран тэдгээрийн бүтэц, зохион байгуулалт нь ялгаатай байна. Ихэнхдээ дээрх байгууллагын удирдлагад бүхий л салбарын хэрэгцээ, шаардлага, оролцоог хангах үүднээс төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөгчдөөс бүрддэг байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГААНЫ АЛБА